

**Монгол Улс**  
**НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Ховд аймгийн**  
**орон нутгийн удирдлагатай хийсэн зөвлөлдөх уулзалт**  
**2017 оны 9-р сарын 19**

*Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл [ibaatarkhuu@worldbank.org](mailto:ibaatarkhuu@worldbank.org) и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.*

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодол сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 19-нд Ховд аймгийн орон нутгийн удирдлага, төрийн байгууллагуудын 8 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

| Ангилал   | Оролцогчдын санал   |
|---|---|
| <b>Улс орны хөгжлийн дүн шинжилгээний талаарх санал (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</b> | <p><b><u>Боломж:</u></b></p> <ul style="list-style-type: none"><li>• Монгол улс уул уурхайн арвин их нөөц баялагтай (гэхдээ энэ нь эргээд баялгийн хараал болсон)</li><li>• Монгол улс нь манай улсад дэмжлэг үзүүлдэг хоёр том хөршийн дунд оршдог.</li><li>• Баруун бүсэд зам тээврийн дэд бүтэц, харилцаа холбоо харьцангуй сайн хөгжсөн.</li></ul> <p><b><u>Сорилт, бэрхшээл:</u></b></p> <p><b>Эдийн засгийн хөгжил, ядуурал:</b></p> <ul style="list-style-type: none"><li>• Эдийн засаг уул уурхайгаас хараат учраас эдийн засгийн өсөлт тогтворгүй байсан. Ихэнх орлого түүхий эдийн экспортоос орж ирдэг. Уул уурхайн бус салбарын хөгжил тааруу.</li><li>• Эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгтэй. Үүнийг баруун бүст хөдөө аж ахуйн түүхийн эдэд түшиглэн үйлдвэрүүд барих замаар хийх боломжтой. Ингэснээр мөн ажлын байр бий болно.</li><li>• Орон нутгийн оролцогчид статистикийн тоо баримтад итгэдэггүй, статистикийн тоо баримтанд тулгуурлан судалгаа, дүгнэлт гаргадаггүй гэдгээ хэлэв.</li><li>• Далайд гарцгүй жижиг зах зээлтэй, хүн ам багатай, өргөн уудам газар нутагтай. Ховд аймаг хилтэй ойрхон байрладаг боловч энэ байршил нь аймагт хөгжилийг төдийлөн их авчраагүй. Мах экспортлох зэрэг зах зээл</li></ul> |

байхгүй. Махны чанар маш сайн боловч орон нутгийн малчид, үйлдвэрлэгчид махаа Улаанбаатар луу хүртэл хүргэж зарах боломж хомс байна.

- Хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжих хэрэгтэй. Ховд аймагт тарьсан хүнсний ногоог хадгалах зориулалтын зоорь нэг ч байхгүй. Үүнээс болж орон нутагт тарьсан хүнсний ногоог хадгалж, жилийн 4 улиралд ашиглах боломжгүй байна.
- Жижиг бизнес эрхэлдэг хүмүүс зөвхөн богино хугацааны ашиг орлогын талаар бодож, урт хугацаанд төлөвлөх боломжгүй байдаг. Жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих хэрэгтэй.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах хөгжлийн том боломж Монголд бий.
- Ядуурлыг бууруулахын тулд эдийн засгийн тогтвортой өсөлт, ажлын байр бий болгох, ажил эрхлэлт болон нийгмийн хамгаалал, халамжийн зохистой тогтолцоон дээр анхааран ажиллах хэрэгтэй.

### **Засаглал**

- Бодлогын тогтворгүй байдал, уялдаа холбоо сул. Засгийн газрын тогтворгүй байдал улс төрийн тогтворгүй байдлаас үүдэж байна.
- Нэгдсэн зохистой стратеги, хөтөлбөрийн төлөвлөлт байхгүй байна. Монгол улсын хөгжлийн урт хугацааны стратеги батлагдсан боловч хэрэгжилт муу байна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 баримт бичгийг хэрэгжилт тал дээр нь анхааран засан сайжруулах хэрэгтэй.
- Бүс нутгийн хөгжлийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй, учир нь Монгол улс шиг өргөн уудам газар нутагтай улс оронд бүс нутгийн хөгжил чухал үүрэгтэй.
- Улс орны урт хугацааны хөгжлийн төлөвлөлт байхгүй байна. Зарим оролцогчид мөн Монгол улсад хуучин байсан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо нь буруу зүйл биш байсан, үүнийг дахин сэргээх хэрэгтэй гэв.
- Засгийн газрын буруу бодлогоос зах зээлийн шударга өрсөлдөөн алдагдсан – аль салбар, аж ахуйн нэгжийг дэмжих вэ гэдэг шийдвэрийг төр засгаас гаргадаг. Эдийн засаг дахь төрийн хэт их оролцоо болон төсвийн санхүүжилттэй төслүүд нь хувийн хэвшил дэх инноваци, шударга өрсөлдөөнийг хааж байна.

### **Бусад**

- Бүс нутгийн харьцангуй даваа тал болон хэрэгцээ шаардлагад тулгуурлан бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн цогц хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй.
- Уул уурхайн салбарын бодлого ил тод байх хэрэгтэй. Ил тод биш, зохисгүй уул уурхайн бодлогоос болж уул уурхайн орлого зөвхөн хэдхэн хүмүүст үр ашгаа өгж байна.

|   |   |
|---|---|
|   | <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн салбар: зээлийн хүү маш өндөр бөгөөд зээлийн шаардлага, шалгуур үзүүлэлтүүд мөн өндөр байдаг, банк санхүүгийн тогтолцоо нь гажуудсан. Банк санхүүгийн тогтолцооны ерөнхий бүтэц буруу байна: санхүүгийн зах зээлийн 90 хувь нь зээл авч байхад зөвхөн 10 хувь нь зээл олгож байна.</li> <li>• Жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх суурь нь эрчим хүч юм. Ховд аймагт тогтвортой эрчим хүчний хангамж асуудалтай хэвээр байна.</li> <li>• Energy resource is the basis of SME development. Currently, our province is still facing the difficulties with sustainable energy supply.</li> <li>• Хүний нөөцийн бодлого алдагдсан. Их дээд сургууль төгсөгчид их байгаа ба тэд ЖДҮ болон бусад ажиллах хүчин шаардлагатай байгаа салбарт ажиллах хүсэлгүй байна. Цалингийн суурь босгыг мөн эргэн харах хэрэгтэй.</li> </ul>   |
| <p><b>ДБГ-ын стратеги, түншлэлийн талаарх санал</b></p> | <p><b>Салбарууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Оролцогчид дараах салбарыг ДБГ-ээс дэмжвэл зохистой тэргүүний салбарууд гэж эрэмбэллээ: (i) хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, экспортыг дэмжих (экспортын бүтээгдэхүүний жагсаалтыг Засгийн газраас боловсруулж, орон нутагт бүтээгдэхүүн бий болгох хэрэгтэй), (ii) дэд бүтцийг дэмжих (зам тээвэр, эрчим хүч), (iii) гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд ЖДҮ-дэд чиглэсэн аж үйлдвэрийн бодлого, (iv) засаглалыг дэмжих, (v) хөдөлмөрийн зах зээлийн бодлого.</li> <li>• ДБГ-ээс дэмжих тэргүүлэх бус салбарууд нь уул уурхай (уул уурхайн түүхий эдийг боловсруулах дунд хэмжээний үйлдвэрүүдийг хөгжүүлэх хэрэгтэй), банк санхүүгийн салбар болон аялал жуулчлал.</li> </ul> <p><b>Арга зам, хэрэгжилт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсад хамгийн орчин үеийн, дэвшилтэт банкны системийн тогтолцоог бий болгоход зөвлөх үйлчилгээг Дэлхийн Банкнаас үзүүлэх хэрэгтэй.</li> <li>• Дэлхийн Банкнаас олгож буй нийт санхүүжилтийн 80 хувийг шууд хөрөнгө оруулалт хэлбэрээр, үлдсэн 20 хувийг чадавх бэхжүүлэхэд зарцуулах хэрэгтэй.</li> <li>• Ядуурлыг устгах зорилго нь улс орны хөгжлийн ерөнхий чиглэлтэй нийцэж байна. Тийм учраас ДБГ боломжит бүх салбарт дэмжлэг туслалцаа үзүүлэх нь зүйтэй.</li> </ul> |

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

|  |   |     |
|--|---|-----|
| Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан        | 6 | 75% |
| Төрийн удирдлага/шинэтгэл                  | 5 | 63% |
| Эрчим хүч                                  | 4 | 50% |
| Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт     | 3 | 38% |
| Худалдаа, экспорт                          | 3 | 38% |
| Боловсрол                                  | 2 | 25% |
| Авлигатай тэмцэх                           | 2 | 25% |
| Хувийн хэвшлийг хөгжүүлэх                  | 2 | 25% |
| Эрүүл мэнд                                 | 2 | 25% |
| Эдийн засгийн өсөлт                        | 2 | 25% |
| Санхүүгийн зах зээл                        | 2 | 25% |
| Зам, тээвэр                                | 2 | 25% |
| Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах | 2 | 25% |
| Хөдөөгийн хөгжил                           | 1 | 13% |
| Хүнсний аюулгүй байдал                     | 1 | 13% |
| Эрх тэгш боломжоор хангах                  | 1 | 13% |
| Хотын хөгжил                               | 1 | 13% |
| Ус, ариун цэврийн байгууламж               | 1 | 13% |
| Байгалийн нөөцийн удирдлага                | 0 | 0%  |
| Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах  | 0 | 0%  |
| Гамшгийн эрсдэлийн удирдлага               | 0 | 0%  |
| Гадаадын хөрөнгө оруулалт                  | 0 | 0%  |
| Нийгмийн хамгаалал                         | 0 | 0%  |
| Бусад                                      | 0 | 0%  |

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

|  |   |     |
|--|---|-----|
| Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих                          | 5 | 63% |
| Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих                                  | 5 | 63% |
| Хүний хөгжлийг дэмжих  | 3 | 38% |
| Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих | 1 | 13% |
| Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих                           | 1 | 13% |
| Бүгд чухал   | 0 | 0%  |